



**“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 26/05

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.3 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам, “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, Blue sky tower, 3 давхар, Toraz HALL танхимд хуралдуулахаар тогтоосугай.

2.Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөллийг томилсугай.

3.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах болон тооллогын комиссыг нэгдүгээр хавсралт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт болон зохион байгуулалтын удирдамжийг хоёрдугаар хавсралт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг гуравдугаар хавсралт, Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг дөрөвдүгээр хавсралт, хурлаар хэлэлцэх асуудлаар “Санал авах хуудас”-ны загварыг тавдугаар хавсралт, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох “Санал авах хуудас”-ны загварыг зургаадугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

4.Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ТӨГСБУЯН

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
03 дугаар сарын 29-ны өдрийн 49 дугаар
тогтоолын нэгдүгээр хэвсрэлт



ХУРАЛД БЭЛТГЭХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:	Г.Батзам	Стратегийн бодлогын төлөвлөлтийн инженер
Гишүүд:	С.Солонго	ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга
	Ч.Энхжаргал	Захиргаа хүний нөөцийн бодлогын хэлтсийн дарга
	Э.Мандахнаран	Хуулийн зөвлөх
	Б.Гэрэлтуяа	Олон нийттэй харилцах мэргэжилтэн
	С.Дэлгэрэх	Мэдээлэл технологийн ахлах инженер

ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:	Э.Мандахнаран	Хуулийн зөвлөх
Гишүүд:	Д.Номин-Эрдэнэ	Ахлах эдийн засагч
	Б.Урантөгс	Хөдөлмөрийн эдийн засагч

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
03 дугаар сарын 19-ны өдрийн 21 дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт



ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН УДИРДАМЖ

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлнэ.

Үүнд:

- 1.1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
- 1.2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
- 1.3. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга;
- 1.4. Компанийн өрийг хувьцаагаар солих тухай;
- 1.5. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай;
- 1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
- 1.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.

2. Санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөр тасалбар болгоно.

3. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдрийг 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөр тус тус тасалбар болгоно.

4. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын тов, байршил, хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, бүртгэлийн өдөр, хурал зохион байгуулах комиссын талаарх мэдээлэл бүхий зарыг 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн дотор өдөр тутмын хоёроос доошгүй сонинд нийтлүүлж, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн цахим хуудсанд байршуулна.

5. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийг 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн "Шивээ-Овоо" ХК-ийн Төлөөлөгчийн газар болон харьяалагдах брокер дилерийн компаниар дамжуулан олгоно.

6. Хувьцаа эзэмшигч нь ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар урьдчилан санал өгч болох бөгөөд саналын хуудсыг хүлээн авах газар, сүүлчийн хугацааг дор дурдсан байдлаар зохион байгуулна.

- 6.1. Саналын хуудас хүлээн авах газар: "Шивээ Овоо" ХК, Улаанбаатар хот, "Хан-Уул" дүүрэг, 3 дугаар хороо, Үйлдвэрийн гудамж, 9 дүгээр байр, "А1" тоотод тооллогын комисс хүлээн авна. Утас: 99017739. "Саналын хуудас"-ыг хүлээн авах сүүлчийн өдрийг харьяалагдах брокер дилерийн компаниар дамжуулан хурал хуралдах өдрөөс долоо хоногийн өмнө

Хурал зохион байгуулах комисс

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны
 03 дугаар сарын 29-ны өдрийн 03 дугаар
 тогтоолын туравдугаар хавсралт



**“ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
 ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

Д/д	Хурлын дэг	Хугацаа, цаг, минут
1.	Хурлын ирц бүртгэх /Тооллогын комисс/	09:00-10:00 цагт
2.	Хурлын ирц мэдээлэх /Зохион байгуулах комисс/	5 минут
3.	Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргыг танилцуулах	5 минут
4.	Хурлын дарга хурлын үйл ажиллагааг нээх хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах	10 минут
5.	Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу танилцуулж хэлэлцүүлэх	Асуудал тус бүрээр 30 хүртэл минут
6.	Хуралд оролцогсдоос асуулт, хариулт	Хүн тус бүрээр 3 мин
7.	Хуралд оролцогсдын санал дүгнэлт	Хүн тус бүрээр 3 мин
8.	Завсарлага	20 минут
9.	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 минут
10.	Хурлаас гарах шийдвэрийн төслийг танилцуулж, батлуулах	Асуудал тус бүрээр 15 минут
11.	Хурлын ажиллагааг хаах	5 минут

Хурал зохион байгуулах комисс

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
03 дугаар сарын 19-ны өдрийн 4 дугаар
тогтоолын дөрөв дүгээр хавсралт



**“ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЗЭЖИТ ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБОГДОХ ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан;
2. Компанийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны тайлан;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл.

Хурал зохион байгуулах комисс

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
03 дугаар сарын 19-ны өдрийн 03 дугаар
тогтоолын тавдугаар хавсралт



**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР САНАЛ АВАХ ХҮҮДАГ**

Хувьцаа эзэмшигчийн овог..... нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо.....

Бүртгэсэн /брокер, дилерийн компани/

Брокерын овог..... нэр.....

“Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, Blue sky tower, 3 давхар, Topaz HALL танхимд хуралдуулсугай.

Д/д	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан
1.	Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан		
2.	Компанийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан		
3.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны тайлан		
4.	Компанийн өрийг хувьцаагаар солих тухай		
5.	Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай		
6.	Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл		

Брокерын/...../

Гарын үсгийн тайлал

Хувьцаа эзэмшигч...../...../

Гарын үсгийн тайлал

2026 онысарын-ны өдөр

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
03 дугаар сарын 19-ны өдрийн 03 дугаар
тогтоолын зургаадугаар хавсралт



**“ШИВЗЭЭ-ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР
ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ САНАЛ АВАХ ХҮҮДАГ**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо:.....

Кумулятив саналын тоо:.....

Бүртгэсэн /брокер, дилерийн компани/.....

Брокерын овог:..... нэр.....

“Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, Blue sky tower, 3 давхар, Topaz HALL танхимд хуралдуулсугай.

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн овог нэр	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
	Ердийн гишүүн	
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		
	Хараат бус гишүүн	
1		
2		
3		
4		

Брокерын /...../

гарын үсгийн тайлал

Хувьцаа эзэмшигч..... /...../

гарын үсгийн тайлал

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана.

Кумулятив арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

Жишээ нь: Та 100 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг гэвэл тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байхад түүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тооцоолсон тохиолдолд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй 100 ширхэг хувьцаа нь 900 саналын эрхтэй $/100 \times 9 = 900/$ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус саналаа өгөх эрхтэй болно.

Саналын хуудсыг ашиглах санамж:

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй тохиолдолд зуучлагч брокерын компани дээр очиж хурлын материалтай танилцаж “Санал авах хуудас”-аар саналаа өгнө.
2. Засварласан болон балласан, залруулгатай “Санал авах хуудас”-ыг хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 88880769 дугаарын утсаар авч тодруулж болно.
4. “Санал авах хуудас” хүчингүй болсон тухай шалтгаан.

2026 оны дугаар сарын өдөр